



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 03 сарын 26-ны
өдрийн 878 дугаарт бүртгээ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 07/06

Арвайхээр

Төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "ж", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд саатуулагдсан тээврийн хэрэгслээс хоногт хураах төлбөрийн хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай. Үүнд:

- 1.1. Мотоцикль /мопед/ - 3000
- 1.2. Бүх төрлийн суудлын автомашин, бага оврын автобус, ачааны автомашин - 8000
- 1.3. Бүх төрлийн том оврын ачааны автомашин, автобус, хүнд машин, механизм - 10000

2. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байранд бүртгэж авснаас хойш 24 цагийн дотор буцаан авсан тохиолдолд түр саатуулах байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

3. Тээврийн хэрэгслийн түр саатуулах байранд тавигдсан иргэдийн өмч хөрөнгө /автомашин, мотоцикль/ тоногдох, үрэгдэх явдал гарч байгаатай холбогдуулан үйл ажиллагааг нь менежентийн гэрээгээр иргэн, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны "Хураамжийн хэмжээ тогтоох тухай" 27 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



А.ИШДОРЖ